

Тавантолгойн талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Тавантолгойн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд М.Энхсайханы илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1. Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээг Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах.
2. Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээний яриа хэлэлцээг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсон гадаадын хөрөнгө оруулалтын тэнцвэртэй байдлыг хангах, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хөшүүрэг болгох, тодорхой салбарт эдийн засгийн дунд, урт хугацааны зорилтыг хангахад чиглүүлэх.
3. Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар өмнө гаргасан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн уялдааг сайжруулах, төслийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд саадгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах.
4. Монгол Улсын иргэдэд олгосон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулж, хувьцааны ноогдол ашиг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.
5. Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээний явц, үр дүнг Улсын Их Хуралд болон олон нийтэд танилцуулж ажиллах.